

## **Үндэсний эрх ашиг нь олон улсын харилцааны тулгуур ойлголт болох нь**

**К.Дэмбэрэл<sup>1</sup>**

*The emergence of nation state led to the concept of national interests. This concept emerged as a hidden base of regulation of international relations. For more than 400 years, this concept of national interest evolutionary changed in content and target. This article is about the concept national interest.*

\* \* \*

Өнгөрсөн хугацаанд бид “үндэсний” гэсэн нэр томъёотой бүхнээс “жийрхдэг” байсан тул “улсын” хэмээх үг хэллэгийг түлхүү хэрэглэж ирсэн. Улсын эрх ашиг, улсын хөгжил, улсын тусгаар тогтнол, улсын хил хязгаар гэх мэт. Улс бүхэн өөрийн гэсэн эрх ашигтай, түүнийгээ хэр оновчтой, бодитой томъёолсон, хэрхэн хамгаалдаг, талаар уншсан, сонссон зүйлийн талаар хүмүүст бага ч атугай ойлголт хүргэх үүднээс саналаа нэмэрлэхийг зорилоо<sup>2</sup>.

Европ дахь 30 жилийн дайны дараагаар буюу 1648 оны Вестфалийн гэрээнээс хойш тэнд хөршүүд нь хүлээн зөвшөөрсөн тодорхой хил хязгаарт, нэгэн хааны удирдлага дор нэгдэж нийлсэн үндэсний улсын тухай ойлголт бий болж улс төрийн харилцааны шинэ түүхийн эх тавигдсан бөлгөө<sup>3</sup>. Чухамхүү, энэ үеэс л үндэсний эрх ашгийн тухай ойлголтыг босгож ярих боломжтой. Учир нь энэ үед л эзэн хааны ч байна уу, дээдсийн ч байна уу эрх ашгийг тодорхой хил хязгарын хүрээнд илэрхийлэх, хамгаалах асуудал гарч эхэлсэн нь лавтай.

---

1. ШУА-ийн Олон Улсын Харилцааны Хүрээлэнгийн ЭШАА, доктор (Ph.D) demberelkolya@yahoo.com

2. Олон улс судлал. 2009, №4

3. Г.Киссенджер. Дипломатия. М., 1997.

Хүн төрөлхтөний түүхэн хөгжил нь тоймлож хэлбэл дараахи шатлалаар өгссөн байдаг. Эхлээд алт мөнгө, авгай хүүхэнг эзэлсэн газраасаа хялбараар “олборлоод” уугуул нутаг руугаа зөөгөөд л сэтгэл нь ханадаг байсан бол дараа нь зөөх явдал чирэгдэл удахгүйгээр тэнд нь эзэмшээд сууж эхэлсэн буюу колончилох үйл явц бий болжээ. Дараагийн үе шатанд худалдааны эерэг баланс буюу ашигтай наймааг илүүд үзэж бэлэн бараа бүтээгдэхүүн борлуулах зах зээлийн төлөө л тэмцэлдэх болсон, өнөөгийн шатанд буюу орчин үед чөлөөт худалдаагаар дамжуулан үндэсний эрх ашгаа илэрхийлэн хамгаалахыг эрхэмлэх боллоо. Эндээс л үндэсний эрх ашиг хэмээх ойлголтын мөн чанар илүү тодорч харагдах боломжтой юм. Өөрөөр хэлбэл, үндэсний эрх ашгийн түүхэн хөгжил, хувьслыг харах боломжтой юм. Дайн байлдаан, колоничлол, дагуур улс, нөлөөний улс, тоглоомын улс, чөлөөт зах зээлийн орон гэсэн томъёоллууд дээрхи хөгжлийн явцаас л урган гарсан. Түүхэн хөгжлийн явцад Үндэсний эрх ашиг нь янз бүрээр нэрлэгдэж ч ирсэн. Үндэсний эрх ашиг нь аливаа улсуудын харилцааны гол үндэс суурь нь болох учиртай. Энэ ойлголт нь тухайн улсын нийгмийг нэгтгэгч хүч ч болдог. Энэ утгаараа олон улсын харилцааны тулгуур ойлголтуудын нэг мөн. Тиймээс орчин үеийн улс төрийн шинжлэх ухаан түүнчлэн олон улсын харилцаанд голлох байр суурийг “үндэсний эрх ашиг” хэмээх ойлголт эзэлдэг.

Үндэсний эрх ашиг гэсэн асуудал шинжлэх ухааны буюу судалгааны түвшинд яригдаж эхлээд 100 шахам жил болж буй ч нэгдмэл нэг ойлголтод өдий хүртэл хүрээгүй байгаа нь төвөгтэй ойлголт гэдгийг харуулж байна. Энэ ойлголтыг гүн ухаан, улс төр, эдийн засаг гэх мэтээр олон талаас нь янз бүрийн байр сууринаас авч үзэж ирсэн.

Үндэсний эрх ашгаа ихэнхи улсууд дараахи байдлаар тодорхойлдог. Үүнд: тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, улс төрийн эрх чөлөө, эдийн засгийн тогтвортой хөгжил. Эрх ашгаа цэгцтэй, зөв томъёолоод дээрхи эрх ашигт маань харшлаж буй болон харшлах зүйлүүдийг гаргаж тавих ба тэдгээрийг саармагжуулах боломжийг судлан хариу арга хэмжээ авах чиглэлд бодлогоо гаргах учиртай юм байна.

Түүнээс гадна аливаа улс бүрт өөрийн гэсэн өвөрмөц эрх ашиг гэж бий. Энэ нь тухайн улсын газарзүйн нөхцөл байдал, дотоод нийгэм, эдийн засаг, улс төрийн нөхцөл, соёл уламжлал, зан заншил, иргэншлийн онцлогтой холбогдон үүснэ. Энэхүү өвөрмөц эрх ашиг нь цаг хугацаа, бодит хүчин зүйл, хөгжлийн явцад “дүр зургаа” өөрчлөх буюу үгүй болж харин шинэ “эрх ашгууд” жам ёсны дагуу гарч ирж болно.

Үндэсний эрх ашиг нь зайлшгүй “зуучлагчаар” дамжин илэрдэг зүйл. Тухайлбал, эзэн хаан, ерөнхийлөгч, парламент, ерөнхий сайд гэх мэт. Үндэсний эрх ашигт олон янзын “жижиг”(нам эвслийн, бизнесийн, санхүүгийн, нийгмийн давхаргуудын г.м.) эрх ашгууд багтдаг ба эдгээр нь үнэндээ “туслах чанартай асуудал” тул зөвхөн хэлэлцүүлгийн үе шатанд л дэлгэрүүлэнгүй авч үзэх шаардлагатай тул энд орхих нь зүйтэй бөгөөд гадаад бодлогод зөвхөн нэгдмэл нэг л үндэсний эрх ашгийн тухай ойлголт явдаг.

Үндэсний эрх ашгийг хоёр бүлэг ойлголтод хуваан, нэгдүгээр бүлэгт хамрах буюу суурь ойлголтыг хэзээ ч үл хөндөх ба хоёрдугаар бүлгийн ойлголтуудыг нийгмийн тогтолцоо, хөгжлийн үе шат, зэргээс хамаарч “гар хүрч” байхаар томъёолдгийг Х.Моргантаугийн тайлбараар дэлгэрүүлье. Ингээд судлаачдын байр суурь уг асуудлаар ямар байдгийг тандъя. Үндэсний эрх ашигт чухам юуг эн тэргүүнд тавих вэ? гэдэгт судлаачид өөр өөр байр суурьтай байсаар ирсэн. Зондерманы томъёолсон “нэг улсын үндэсний эрх ашиг нөгөө улсын үндэсний эрх ашигт нийцэж байх ёстой” гэсэн сонгодог хэмээн үзэж болохуйц томъёолол ч бий. Нэн ялангуяа, жижиг улсуудад илүү нийцтэй зүйл.

1934 онд түүхч Ч.Бирд нарын бичсэн “Үндэсний эрх ашгийн үзэл санаа” хэмээх бүтээл энэ чиглэлд анхных нь. Үндэсний эрх ашгийг нийгмийн тогтолцооноос нь хамаарч династийн, төрт ёсны, ард түмний, ангийн гэх мэтээр ангилж ч байсан. А.Мэхэн, Р.Осгуд, Ж.Чейз, А.Жорж, Р.Кеохан зэрэг судлаачдын томъёолсон Үндэсний эрх ашиг нь ерөнхийдөө дараахи чиглэлүүд багтаж байна. Үүнд: газар нутгийн бүрэн бүтэн байдлыг хамгаалах, гадаад далайд хяналт тавьж байх боломжтой газар нутаг олж авах, улс төрийн хувьд тусгаар байх, төр засгийн үндсэн институцийг дэмжих, дайснуудаас цэргийн

баазаа хамгаалах, хилийн чанадад өөрөө удирдах ёс, ардчиллыг дэмжих, худалдааг хамгаалж хөгжүүлэх, дэлхий дахинаа хүчний тэнцвэрийн хувьд таатай системийг бүрдүүлэхэд туслах, хүн хүссэн газраа амьдрах, эрх чөлөөтэй байх (төрөөр хамгаалуулах, засаглалын хэлбэрийг сонгох г.м), эдийн засгийн хувьд оршин тогтнох (эдийн засгаа өсгөн өргөжүүлж байх) гэх мэт. Үндэсний эрх ашигт “үнэт зүйлс” мэтийн үзэл суртлын ойлголтуудыг оруулах эсэх асуудал өдий хүртэл судлаачдын дунд маргааны сэдэв хэвээр байгаа. Реализмын гол төлөөлөл болох Х.Моргантау нь “үндэсний сонирхол”-ыг тодорхойлохдоо “power”-г гол болгож тэр талаас нь “интерес” хэмээх ойлголтыг тайлбарлахыг гол болгодог. Үндэсний эрх ашиг нь “power”-аас шууд хамааралтай зүйл. Х.Моргантау үндэсний эрх ашиг, “хүчний тэнцвэр” гэсэн хоёр ойлголтыг дүйцүүлж тавьсан байдаг. Түүний үзэж буйгаар үндэсний сонирхол нь мөнхийн сонирхол, хувьсагч сонирхол хэмээх 2 хэсгээс бүрддэг аж. Мөнхийн сонирхол нь дотроо бүрэн утгаараа хамгаалагдсан, улс төрийн хүрээлэлд орсон, зохистой боловч хязгаарлагдмал зорилго бүхий үндсэн гурван зүйлийг агуулсан байх ёстой гэнэ. Г.Моргантау нь “үндэсний сонирхол”-ыг нэмж томъёолохдоо, тэрээр нэгдүгээрт, тухайн улс нь өөрийн улс төр, эдийн засаг, соёлын хөгжилдөө нийцсэн газарзүйн онцлог, хоёрдугаарт, зохистой, хэм хэмжээгээ мэдэрсэн улс төрийн бодлогодоо тус тус суурилсан байх ёстой<sup>4</sup> гэжээ.

Үндэсний сонирхлыг тайлбарлах, ойлгох, таниулах зэрэгт АНУ-д бүхэл бүтэн номлол бий болж ном сурах бичиг ч хангалттай гарчээ. Харин Францын социологчидын төлөөлөл 1980-аад онд үндэсний сонирхол, зорилгын талаар судалгааг түлхүү тавьж эхэлсэн. Тэдний үзэж буйгаар үндэсний сонирхлыг тодорхойлохдоо мөнхийн сонирхлоо хамгаалахдаа аюулгүй байдал сахих, хүчээ нэмэгдүүлэх, алдар сууг зорихын зэрэгцээ орон зай, газар нутгаа өргөтгөх, хүн амаа өсөх, хүний оюун санаа, хүсэл зоригийг эзэмдэхийн төлөөхи тэмцэл ажээ.

Идеалист угшлын судлаачид, улс төрчид үндэсний эрх ашгийг тайлбарлахдаа олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд тулгуурладаг. Тухайлбал, НҮБ-ын дүрэм, Хельсинкийн акт зэрэгт аливаа улсын

---

4. П.А.Цыганков. Международные отношения. М., 1996.

үндсэн болон түгээмэл эрх ашгуудыг тусгасан байдаг. Эдгээрт тухайн улсын оршин тогтнох, улс төрийн тусгаар байдал, дотоод хэрэгт нь хөндлөнгөөс үл оролцох, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын дархан байдал зэргээр томъёолсон.

Францын олон улсын харилцааны судлаач Ж.Б.Дюрозель, тэрээр тухайн лидерийн дэвшүүлсэн үндэсний сонирхлыг бодит хэмээх үндэсний сонирхолтой харьцуулах боломжгүй тул ямар нэг субъектив зүйл рүү орчихдог юм байна. Тиймээс үндэсний сонирхлыг тодорхойлох боломжгүй тул “үндэсний ижил төстэй байдал”-г олон улсын харилцааны субъектуудын үйл ажиллагааг сэдэрэх зүйл хэмээн авч үзэх боллоо.

Үндэсний ижил төстэй байдлын үндэс нь хэл, түүх соёл, шашин зэрэг болно. Реалистууд нь үндэсний ижил төстэй байдлыг “Үндэсний сонирхол”-ын салшгүй нэг хэсэг нь хэмээн үздэг. Ямарваа нэг сонирхлын үндэс нь бодит хэрэгцээ байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн нийгмийн буюу тухайн субъектын бодит шаардлага болно. Нийгмийн хэрэгцээг танин мэдэх үйл явц нь хүний сонирхлын бүрдэх үйл явц мөн. Эдгээрт л үндсэн анхаарлаа хандуулах ёстой.

Орчин үед үндэсний сонирхол өөрчлөгдөж байгаа нь шинжлэх ухааны хөгжил, даяаршил, интернационализация зэрэгтэй холбоотой. Хүн төрөлхтөн оршин суугаа дэлхий дахины нийтлэг эрх ашгийг давхар бодолцохгүй бол глобал асуудал ихээр гарах болсон. Хэдий тийм ч глобал асуудлын хүрээнд аливаа улсын дагнасан эрх ашгийг хавчуулах нь олонхийн эрх ашигт үл нийцнэ.

Эрх ашиг гэдэг нь бодит шаардлагын илэрхийлэл төдийгүй хүний үйл ажиллагааг өдөөгч зүйл. Хүн томъёолдог тул уг чанартаа субъектив, хийсвэр зүйл. Эрх ашиг нь тодорхой бодлогод “сууж” өгснөөр зорилго болон хувирна. Үндэсний эрх ашиг нь бодит шаардлагад хэр нийцэж буй нь нийгэм, төрийн шинж чанар, улс төрийн хүчнүүдийн хүчний харьцаанаас ч хамаарна. Үндэсний эрх ашгийг олон улсын тавцан дээр хэн, ямар үүрэг, хариуцлагатайгаар хэрэгжүүлэх вэ? гэсэн асуудалд бид мөн анхаарах нь зүйтэй.

Судалгааны ажил нь нэг улсаас нөгөө улсдаа эсвэл нэг үндэстнээс нөгөө үндэстэндээ эрх ашгаа тулган илэрхийлсэн цаг үе, түүний бодит шалтгааныг хэрэгжилтийн хамтаар судлахад чиглэгдсэн тул уг судалгааны тулгуур буюу үндсэн ойлголт болсон “ҮНДЭСНИЙ ЭРХ АШИГ” хэмээх ойлголтыг эхлээд тодруулах судалгааг энэхүү өгүүлэлд харуулахыг хичээлээ.

“ЗХУ-ын эрх ашиг” хэмээх ойлголтод орос, украин, хасаг, литва, эстони, татар, халимаг, гүрж, армян гээд тухайн улсын бүрэлдэхүүнд байсан бүхий үндэстний эрх ашиг хамаарна. Үндэсний эрх ашиг гэж хэний эрх ашгийг хэлэх вэ?, түүнийг хэн, хэрхэн тодорхойлдог вэ? хэмээх зүйлүүд тодорхой хариултаа хүлээж л байгаа. Зарим хүмүүсийн хувьд төрийн өндөр албан тушаалтан, улс төрчдийн дэвшүүлсэн үндэсний эрх ашгийг тодорхойлолтын хамт хүлээн авч хэрэгжүүлэх ёстой гэсэн хувилбар ч бий.

Аливаа улсын гадаад улс төрийн үйл ажиллагаа нь түүний лидерийн үйл ажиллагаагаар илэрхийлэгддэг ба лидер нь сонголт хийх эрх бүхий байдаг. Эдгээр эрх бүхий лидерүүдийн үйлдэлд нь ихээхэн нөлөө үзүүлдэг зүйлс нь идеологи, амбици, темперамент зэргээр уг лидерийн зан чанараас ихээхэн хамаардаг бөлгөө. Гэхдээ тэдгээр лидерүүд нь өөрсдийн хувийн тэр зан араншингаа тайлбарлахдаа үндэсний сонирхол, үндэсний эрх ашгийн төлөө хийсэн хэмээн харуулахыг ч бас зорьдог. Энэ нь зорилго нь аргаа зөвтгөдөг гэдэгт нийцнэ. Тийм ч учраас миний судалгаанд ЗХУ-ын эрх ашиг нь “Сталины”, “Хрущевын”, “Брежневын” хэмээн томъёологдсон болно.

Үндэсний аюулгүй байдал гэж юу вэ? энэ нь ердөө үндэсний эрх ашгаа хамгаалах л стратеги. Үндэсний аюулгүй байдлын бодлого гэж байдаг, энэ бодлого нь үндэсний эрх ашгийг (улсын эрх ашиг гэж ч ойлгож болно) хамгаалах нэг л зорилготойгоор томъёологдох ёстой. Үндэсний сонирхол, зорилго хоёр олон улсын харилцаанд нэгэн ойлголт болж явдаг. Зорилгоо тодорхойлох арга нь сонирхлоо тодорхойлох аргатай ихэд ойролцоо буюу давхцдаг, ижил төстэй зүйл бөлгөө. “Нэг хуучин анд, хоёр шинэ найзаас хавьгүй илүү” гэсэн хэлцүг ч үндэсний сонирхолд дагалдаж явдаг.

АНУ-ын “Үндэсний аюулгүй байдлын стратеги” баримт бичигт үндэсний эрх ашгийг “амин чухал” эрх ашиг, “чухал” эрх ашиг, “хүмүүнлэнгийн болон бусад” эрх ашиг хэмээн 3 үндсэн ангилалд хуваагаад “амин чухал” эрх ашгийг хангахад шаардлагатай гэж үзвэл дангаараа цэргийн хүчийг хэрэглэхээр заасан. “Чухал” эрх ашигт АНУ-ын сайн сайхан байдал, хөгжил дэвшил, эдийн засгийн ашиг сонирхол, холбоотны өмнө хүлээсэн үүрэг зэргийг багтаадаг. “Бусад” хэмээх эрх ашигт ардчилал, хүний эрхийн үзэл санааг дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлэх гэх мэтийн зүйлсийг багтаажээ. Жил бүр батлагддаг “Төрийн департаментын стратегийн төлөвлөгөө” нь чухамхүү дээрхи эрх ашгийг хэрэгжүүлэх “бизнес-төлөвлөгөө” нь юм.

АНУ-ын хувьд дээрхи “амин чухал” эрх ашгаас гадна, 12 “онцгой чухал” эрх ашиг (дэлхийн чухал бүс нутаг дахь мөргөлдөөнийг таслан зогсоох, зайлуулах, АНУ руу чиглэсэн хяналтгүй цагаачлалыг зогсоох гэх мэт), 11 “чухал” эрх ашиг (хүний эрхийг зөрчих асуудлыг зогсоох гэх мэт), 5 “орхигдуулж болохгүй” эрх ашиг (худалдааны тэнцвэртэй бус байдлыг болиулах, бусад улсуудад ардчиллыг өргөжүүлэх г.м.). Эдгээр 28 эрх ашгийг ерөнхийд нь “чухал” эрх ашгууд хэмээн багцалдаг. Өөрөөр хэлбэл, АНУ-ын эрх ашиг нь 5 “амин чухал”, 28 “чухал” эрх ашигт багтаж байна гэсэн судлаачдын нарийвчилсан дүгнэлт ч бий.

Үндэсний аюулгүй байдлын асуудлаар ОХУ-ын хувьд “Орос улс дэлхийн хамтын нийгэмлэгт”, “Орос улсын үндэсний эрх ашиг”, “ОХУ-ын үндэсний аюулгүй байдлын заналхийллүүд”, “ОХУ-ын үндэсний аюулгүй байдлыг хангах” гэсэн 4 бүлэгтэй баримт бичиг бий. Түүнийг нь “ОХУ-ын Үндэсний аюулгүй байдлын концепци” хэмээн тунхагласан. Оросын зарим судлаачдын үзэж буйгаар энэхүү аюулгүй байдлын концепци нь найруулга талаасаа ч, агуулга талаасаа ч Орос шиг олон үндэстний, “асуудал” ихтэй улсад “тохирохгүй” аж. Бидний хувьд дэлхийн бодлогод тодорхой байр суурьтай энэ улсын аюулгүй байдлын концепцийг зөв үү, буруу юу гэх нь илүүц боловч энэ улс үндэсний эрх ашгаа хэрхэн томъёолж бодлогоо хааш нь хандуулах вэ гэдэг нь чухал зүйл.

Судлаачийн хувьд бодоход БНХАУ нь үндэсний эрх ашгаа дараахи хэлбэрээр томъёолох болов уу. Үүнд: одоо байгаа нийгмийн

байгууламжийг хадгалах, улс орноо задраахгүйгээр бүрэн бүтэн байдлаа сахин хамгаалах гэх мэт.

Үндэсний эрх ашгаа гадаад бодлогоороо хэрхэн хамгаалах вэ? гэдэг асуудал ч чухал байсаар ирсэн. Олон улсын харилцаанд оролцогчдын зорилгод дүн шинжилгээ хийх нь хамгийн төвөгтэй асуудлын нэг. Ямар зорилготой, юу хүсээд байгааг яг таг тодорхойлох нь хүндрэлтэй гэсэн үг. Гол нь энэхүү үйл ажиллагааг хүн л явуулж байгаа тул тэдний үр дагавар гэдэг нь хэн нэгэнд таалагддаг, зарим нэгэнд таалагддаггүй гээд нэгдмэл дүгнэлт хийхэд төвөгтэй. Энэ утгаараа гадаад бодлогын үйл ажиллагааны зорилгод хийх дүгнэлт тийм ч амар ажил бус.

Уг субъектын хэд хэдэн үйл ажиллагааны үр дагавраас дүн шинжилгээ хийх нь тухайн субъектын үйл ажиллагааны зорилгыг мөн чанарт нь тулгаж тодорхойлох нэлээн бодит арга хэрэгсэл мөн. Олон үйл ажиллагааны үр дагаврыг нь харж дүгнэлт хийхгүй бол нэг удаагийн үйлдлээр, тухайлбал, хэн нэгэнд дайн зарласнаар дүгнэвэл тэр нь өрөөсгөл болох талтай, нэг ЗГ-ын нэр хүнд унаснаа цайруулахаар хэн нэгэнд дайн зарлаж нэр хүндээ өсгөх нь нэг удаагийн тохиолдол бөгөөд түүгээр хоёр орны сонирхол, зорилгыг тодорхойлж үл болно. Бид тухайн улсын зүгээс манайх руу чиглэн явуулж буй бодлогын зорилт, сонирхлыг тодорхойлохдоо тухайн улсын зүгээс манайд буй эрх ашиг хэмээн томъёолж байгаа.

## **НОМ ЗҮЙ**

- Введение в теорию международных отношений и анализ внешней политики. Санкт-Петербург., 2001.
- Г.Киссинджер. Дипломатия. М., 1997.
- Morgentau H. Politics among Nations. The struggle for power and peace. N.Y., 1949.
- Contemporary Theory in International Relations. – Prentice Hall, 1969.

- Rosenau J. National Interest/ International Encyclopedia of the Social Sciences. N.Y., 1968.
- Kenneth N.Waltz “Realism and International politics, NY.2008
- Кокошин А.А. 2001. Феномен глобализации и интересы национальной безопасности // Мир и Россия на пороге XXI века. Вторые Горчаковские чтения. М.
- Нарочницкая Н.А. Национальный интерес России // «Международная жизнь», № 3-4.
- Сорокин К.Э. Государственные интересы как обобщение национальных // «Полис», № 1.
- Хрусталева М.А. 1999. Эволюция системы международных отношений и особенности ее современного этапа // «Космополис». Альманах. М.
- Шейнис В.Л. 2003. Национальные интересы и внешняя политика России // «Мировая экономика и международные отношения», № 4.
- Рациональный эгоизм национального интереса // Полис. 1995. No 1. С. 92.
- Г.Төмөрчулуун. Жижиг улсын гадаад бодлогын шийдвэр гаргалт. УБ.,